

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түмэнцогт ус дулаан ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/12/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: О.Барчидгүнсэн Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
3. Аудитын тайлан.....	6
3.1 Ерөнхий зүйл.....	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
Байгууллагын үйл ажиллагаа.....	8
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ААТҮГ	Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.08 № 105
танай _____-ны № _____-т

ТҮМЭНЦОГТ УС ДУЛААН ААТҮГ-ЫН
ДАРГА Б.ЛЭГЗИЙМАА
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, тодруулгыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	213,575.89	504,023.14
1.1.2	Дансны авлага	7,888,652.14	5,845,995.26
1.1.4	Бусад авлага	6,988,308.46	6,208,443.94
1.1.6	Бараа материал	57,165,121.69	10,321,969.51
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	72,255,658.18	22,880,431.85
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,683,735,103.54	1,548,640,379.10
1.2.2	Биет бус хөрөнгө	14,192,000.00	14,192,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,697,927,103.54	1,562,832,379.10
1.3	Нийт хөрөнгийн дүн	1,770,182,761.72	1,585,712,810.95
2.1.1.1	Дансны өглөг	42,110,078.11	13,746,695.38
2.1.1.3	Татварын өр	27,724,784.52	10,353,956.68
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	87,000,000.00	39,282,127.76
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	156,834,862.63	63,382,779.82
2.2	Өр төлбөрийн нийт дүн	156,834,862.63	63,382,779.82
2.3	Өмч	2,959,592,416.76	2,959,592,416.76
2.3.1	-төрийн	2,959,592,416.76	2,959,592,416.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-1,346,244,517.67	-1,437,262,385.63
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,613,347,899.09	1,522,330,031.13
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,770,182,761.72	1,585,712,810.95

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	308,343,237.43	358,564,864.09
2	Борлуулалтын өртөг	129,398,992.82	198,635,906.55
3	Нийт ашиг (алдагдал)	178,944,244.61	159,928,957.54
8	Бусад орлого	2,000,000.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	555,000,372.19	229,315,367.12
11	Санхүүгийн зардал	93,360.00	17,728,010.15
12	Бусад зардал	1,652,000.00	3,802,853.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	100,595.23
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-377,801,487.58	-91,017,867.96
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-377,801,487.58	-91,017,867.96
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-377,801,487.58	-91,017,867.96
24	Орлогын нийт дүн	-377,801,487.58	-91,017,867.96

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,959,592,416.76	0.00	0.00	0.00	-968,443,030.09	1,991,149,386.67
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
2	Залруулсан үлдэгдэл						
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	-377,801,487.58	0.00
4	Бусад дэлгэрэнгүй орлого						
5	Өмчид гарсан өөрчлөлт						
6	Зарласан ногдол ашиг						
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,959,592,416.76	0.00	0.00	0.00	-1,346,244,517.67	1,613,347,899.09
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
2	Залруулсан үлдэгдэл						
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	-91,017,867.96	-91,017,867.96
4	Бусад дэлгэрэнгүй орлого						
5	Өмчид гарсан өөрчлөлт						
6	Зарласан ногдол ашиг						
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	2,959,592,416.76	0.00	0.00	0.00	-1,437,262,385.63	1,522,330,031.13

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1	Мөнгөн орлогын дүн	363,313,813.20	394,080,878.63
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	351,313,813.20	384,048,418.63
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,108,320.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	32,460.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	12,000,000.00	10,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	365,615,112.19	393,790,431.38
1.2.1	Ажиллагчдад төлсөн	109,272,760.79	110,491,737.01
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	45,138,097.69	36,254,570.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	50,927,730.00	37,223,632.73
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	91,561,652.44	90,911,587.27
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	47,843,905.03	52,516,517.83
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	20,570,056.24	66,311,686.33
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	208,350.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	92,560.00	80,700.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-192,978.99	290,447.25
3.1	Мөнгөн орлогын дүн	8,000,000.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	8,000,000.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	8,416,000.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	8,416,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-416,000.00	0.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-608,978.99	290,447.25
5	мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	822,554.88	213,575.89
6	мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	213,575.89	504,023.14

№	Эдийн засгийн үзүүлэлт	2020 он		2021 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	2	3	4	6	7
1	Нийт орлого	318,457,998.60	308,343,237.43	320,785,651.50	358,564,864.09
	Үүнээс: Цэвэр орлого	318,457,998.60	306,343,237.43	320,785,651.50	348,564,864.09
	Үйл ажиллагааны бус орлого		2,000,000.00		10,000,000.00
2	Нийт зардал	313,069,300.00	686,144,725.01	325,013,153.36	486,889,104.29
	Борлуулалтын өртөг	180,877,000.00	129,398,992.82	191,477,628.92	198,635,906.55
	Үүнээс: Удирдлагын зардал		176,852,393.70		229,315,367.12
	санхүүгийн зардал		93,360.00		17,728,010.15
	бусад зардал		1,652,000.00		3,802,853.00
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)				100,595.23
	элэгдлийн зардал	132,192,300.00	378,147,978.49	133,535,524.44	87,276,256.95
	татварын өмнөх ашиг /алдагдал/		-377,801,487.58		-91,017,867.96
3	Нийт ажиллагсдын тоо	20	20	20	22
4	Нийт цалингийн сан	130,000,000.00	125,430,713.00	136,000,000.00	133,970,521.92
5	Нэг ажилтаны дундаж цалин	541,667.00	522,628.00	567,000.00	507,464.00
8	Хөрөнгө орлуулалт	342,000,000.00	40,000,000.00		
7	Нийт авлага	28,329,898.80	14,876,960.60	14,876,960.60	12,054,439.20
	Үүнээс найдвартай	18,645,960.34	7,888,652.14	7,888,652.14	5,845,995.26
	бусад авлага	9,683,938.46	6,988,308.46	6,988,308.46	6,208,443.94
	Найдваргүй				
8	Нийт өглөг	66,867,183.55	69,834,862.63	69,834,862.63	24,100,652.07
	Үүнээс Богино хугацаат өр төлбөр	40,902,530.23	42,110,078.11	42,110,078.11	13,746,695.39
	Урт хугацаат өр төлбөр				
	татварын өглөг	15,584,619.57	27,724,784.52	27,724,784.52	10,353,956.68
	НДШ өглөг	10,380,033.75			

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь “Үйлдвэрлэлийн чанарыг дээшлүүлэх, сумын хэрэглэгчдийг дулаанаар хангах, унд ахуйн чанар стандартад тохирсон усыг олборлон түгээх, хэрэглээний явцад гарсан бохир ус, хог хаягдлыг татан зайлуулах ажлыг хэвийн явуулах” гэсэн эрхэм зорилго, зорилт дэвшүүлсэн айна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 449.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажиллагаа

Түмэнцогт ус дулаан ААТҮГ - ийн зорилго нь тус сумын хэрэглэгчдийг дулаанаар хангах, унд ахуйн чанар стандартад тохирсон усыг олборлон түгээх, хэрэглээний явцад гарсан бохир ус, хог хаягдлыг татан зайлуулах ажлыг хэвийн явуулах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл оршино. Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх үйл ажиллагаа, ус хуримтлуулах, ариутгах, төвлөрсөн ус хангамжийн үйлчилгээ, хог хаягдлыг татан зайлуулж, нэгдсэн хогийн цэгт төвлөрүүлэх, гэрээ, төлбөрт үндэслэн хийгдэх дулааны болон ус сувгийн шугам сүлжээ, сантехникийн засвар үйлчилгээ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар статустай байна. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд дулаан үйлдвэрлэл, түгээлт хослон эрхлэх, ус хуримтлуулах, ариутгах, төвлөрсөн ус хангамж үйлчилгээ, гэрээ төлбөрт үндэслэн хийгдэх дулааны болон ус сувгийн шугам сүлжээ, сан техникийн засвар үйлчилгээ үзүүлэх чиглэлтэй байна. Өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь Түмэнцогт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 28 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд бүртгэлийг сайжруулж анхан шатны бүх худалдан авалтыг сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлэн НӨАТ баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас бүрэн авч ажиллажээ.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин

хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоогоор 20 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 20 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 979.9 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.2	0.5	0.3
Авлага	15.0	12.0	-2.9
Бараа материал	57.0	10.3	-46.6
Үндсэн хөрөнгө	1,683.7	1,548.6	-135.0
Биет бус хөрөнгө	14.1	14.1	0
Нийт хөрөнгийн дүн	1,770.1	1,585.7	-185.0
Өр төлбөрийн дүн	156.8	63.3	-93.4
Богино хугацаат өглөг	69.8	24.1	-45.7
Урьдчилж орсон орлого	87.0	39.2	-47.7
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,613.3	1,522.3	-91.0
Эздийн өмч	1,613.3	1,522.3	-91.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,770.1	1,585.7	-184.4

Харилцахын үлдэгдэл 0.5 сая төгрөг болж өссөн нь орлогоос харилцах дансанд үлдсэн байна.

Авлага 12.0 сая төгрөг болсон нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу чөлөөлсөн дулааны авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10.3 сая төгрөг болж 46.6 сая төгрөгөөр буурсан нь засвар үйлчилгээнд зарцуулсан материал буурсан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,585.7 сая төгрөг болж 185.0 сая төгрөгөөр буурсан нь дээд шатны төсөв захирагчаас аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 42 дугаар тогтоолоор 73.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж данснаас хасагдаж, элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 63.3 сая төгрөгийн өр төлбөр байна. Энэ нь тайлант оны НӨАТ-ийн төлөгдөөгүй өрийн үлдэгдэл болон нүүрсний өглөгийн үлдэгдэл байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3.20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 320.7 сая төгрөгөөр, нийт зардлыг 325.0 сая төгрөгөөр, 84.3 сая төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээнд арга хэмжээнд 77.0 сая төгрөгийг төлөвлөж, аймгийн орон нутгийн өмчийн газарт тайлангаа жил бүр тайлагнадаг боловч ИТХ-аас баталж өгөөгүй байна

Гүйцэтгэлээр 358.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 449.7 сая төгрөгийн зардал гарган, 91.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь урьдчилж орсон орлогоо бүртгэсэн хөрөнгийн тухай жилийн элэгдлийн зардал.

Нийт орлогын гүйцэтгэл 358.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 37.8 сая төгрөг буюу 11.8 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 449.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 124.7 сая төгрөг буюу 38.3 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 91.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 6.7 сая төгрөгөөр илүү байгаа нь урьдчилж орсон орлогоо бүртгэсэн хөрөнгийн тухай жилийн элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн дотоод хяналт байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Түмэнцогт ус дулаан ААТҮГ-ын тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илэрсэнгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.